

### **Ажлын зорилго:**

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, багасгах, ангилан ялгах, дахин ашиглах, боловсруулах хог хаягдлын менежментийн шатлалыг бий болгох. Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэхэд оршино.

### **Ерөнхий мэдээлэл:**

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд ашиглагдахгүй болсон (хугацаа дууссан, нэр томъёо тодорхойгүй гэх мэт) химийн хорт болон аюултай бодисыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжид шилжүүлэх.

### **Ажил гүйцэтгэх үндэслэл:**

- Монгол улсын хог хаягдлын тухай хуулийн 10.2.5 дахь заалт, Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмын 2.3.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах.

- Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 354 дугаарын албан бичиг.

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны Байгаль орчныг менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.

#### **Ач холбогдол:**

Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулах, хадгалах, устгах, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлснээр байгаль орчинд болон хүн амьтны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

#### **Хамрах хүрээ, ажлын хэмжээ:**

Бүтцийн нэгжүүдээс үүссэн аюултай хог хаягдал.

## **I. АЖЛЫН ДААЛГАВАР**

1. Гүйцэтгэгч байгууллага нь Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хууль болон холбогдох дүрэм, журам, стандарт, техникийн шаардлагад заасны дагуу хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, шилжүүлэн авах ажлын хуваарь, төлөвлөгөөг боловсруулж ирүүлнэ.

2. Гүйцэтгэгч байгууллагын товч танилцуулга, үйл ажиллагааны чиглэл, харилцах утас, ажил, үйлчилгээний үнийн санал ирүүлнэ.

3. Аюултай хог хаягдлыг устгах үйлчилгээний хөлсийг дараах жишиг үнийн саналыг харгалзан гаргах.

№	Төрөл	Хэмжих нэгж	Нэг бүрийн хөлс /төгрөг/	Хаягдлын хэмжээ	Нийт хөлс /мян.төг/	Нийт /мян.төг/
1	Органик бодисын хаягдал	кг	17,042	5,199.135	88,603.659	175,600.006
2	Органик бус бодисын хаягдал	кг	5,200	296.783	1,543.272	
3	Хүчил, шүлтийн хаягдал	кг	9,615	14.7	141.341	
4	Үл мэдэгдэх бодисын хаягдал	кг	11,020	8.2	90.364	
5	Фильтер	кг	4,500	6,021.8	27,098.1	
6	Тортог	кг	17,042	2,000.0	34,084.0	
7	Принтерийн хор	кг	7,000	291.3243	2,039.27	
8	Давирхай	кг	5,500	4.0	22,000.0	

Тайлбар:

1. Дээрх үнэнд бүх төрлийн устгах шаардлагатай химийн бодис цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйлчилгээний хөлс, НӨАТ орсон болно.
2. Устгах шаардлагатай химийн бодисыг хүлээж авахдаа жинлэж авна.
3. Үйлчилгээний хөлсийг 2017.05.12-нд УИХ-аар батлагдсан “Хог хаягдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын 4.1.32 дахь заалт “аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс” гэж аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, хадгалах, устгахад шаардагдах зардлын мөнгөн дүнг гэж тооцно.
4. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын тухайн жилийн үйл ажиллагаанаас шалтгаалан төсөвт өртөгт тохируулан төрөл, тоо хэмжээнд өөрчлөлт оруулж болно.
5. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулахдаа дээрх заалтыг мөрдөнө.

## II. ГҮЙЦЭТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Тухайн ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 4.1.24, 4.1.39, 4.1.40 дахь заалт, Засгийн газрын 116-р тогтоолоор батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ын 2.3.4-т заалтыг дагаж мөрдөх.

2. Ажлыг гэрээт хугацаанд чанарын шаардлага хангахаар бүрэн гүйцэтгэх.

3. Гүйцэтгэгч байгууллага нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг бүрэн хариуцах.

4. Техникийн баримт бичиг боловсруулах, санал дүгнэлт гаргах, ажил, үйлчилгээг явуулах чадамжтай байх.

5. Гүйцэтгэгч байгууллагын аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь шаардлага хангасан тэмдэг тэмдэглэгээтэй, бусад дагалдах бичиг баримт (аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ачилт хийх үеийн зааварчилгаа, ослын үед авах арга

хэмжээний төлөвлөгөө гэх мэт), материалууд (даруулга, бүтээлэг, эвүүрэг, чингэлэг, галын хор гэх мэт)-ыг бүрэн хангасан байх.

6. Гүйцэтгэгч байгууллагын ажилтнууд нь “Хог хаягдлын тухай” хуулийн 26.1.3 заалтын дагуу аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах ажлын байрны шаардлагад нийцсэн болон ачилт хийх сургалтад хамрагдсан байх.

7. Тухайн чиглэлээр ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх.

8. Гүйцэтгэгч байгууллага нь үйлдвэрийн газрын мэдээллийн аюулгүй байдлыг чандлан хадгалах.

### **Ш. ТУСГАЙ ШААРДЛАГА**

1. Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 37.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тус хуулийн 8.1.4-т заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас авсан байх.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хавсралтын хамт ирүүлэх.

3. Засгийн газрын 116-р тогтоолын 1-р хавсралтын дагуу аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмыг мөрдөх.

4. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас боловсруулж, баталсан “Гаднын байгууллага, хувь хүмүүст дахивар нөөцийг худалдан борлуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэх журам”-ыг дагаж мөрдөх.

5. Гүйцэтгэгч байгууллагын агуулах нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас хүлээн авсан аюултай хог хаягдлыг хадгалах багтаамжтай байх.

6. Гүйцэтгэгч байгууллага нь аюултай хог хаягдлыг шилжүүлэн авах техникийн (ачигч, тэвштэй ачааны автомашин гэх мэт) чадамжтай байх.

7. Гүйцэтгэгч байгууллага нь аюултай хог хаягдлыг ачих, шилжүүлэн авах боловсон хүчний чадамжтай байх.

8. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын тухайн жилийн химийн хорт болон аюултай бодисууд болон аюултай хог хаягдлын төрөл, тоо хэмжээнээс шалтгаалан өөрчлөлт оруулж болно.

9. Гүйцэтгэгч байгууллага нь аюултай хог хаягдлыг өөрийн техникээр шилжүүлэн авна.

10. Аюултай хог хаягдлын ачилтын үед гэрээт компани нь эрх бүхий төлөөллөө байлцуулан хүлээж авах.

11. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулахдаа дээрх заалтыг мөрдөнө.

### **АЖЛЫН ҮЕ ШАТУУД**

- Сонгон шалгаруулалт явуулах, гэрээ байгуулах.
- Аюултай хог хаягдлыг шилжүүлэх.
- Ажлын гүйцэтгэлээр акт үйлдэх.
- Төлбөрийг улиралаар олгох.

### **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

#### **Хууль эрх зүйн шаардлага:**

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас авсан тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй байх.

- МУ -ын Хог хаягдлын тухай хууль, ЗГ-ын 116-р тогтоол болон холбогдох дүрэм журмуудыг мөрдөх.

#### **Байгаль орчны шаардлага:**

- Үйлдвэрийн газрын “Гаднын байгууллага, хувь хүмүүст дахивар нөөцийг худалдан борлуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллах.

#### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага:**

- Үйлдвэрийн газрын ХАБЭА-н дүрэм, дотоод дүрэм, журмыг мөрдөн ажиллах.

### **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА**

- Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 жил байна.

### **ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

- Гүйцэтгэгч байгууллага захиалагчийн Байгаль орчин, ногоон хөгжлийн хэлтсийн удирдлагад ажлаа тайлагнах.